

Мөн зорчигч 15 саяас дээш төгрөг, эсхүл түүнтэй тэнцэх хэмжээний гадаад валют, санхүүгийн хэрэгсэл, цахим мөнгийг Монгол Улсын хилээр бэлнээр нэвтрүүлэх бол энэ тухай гаалийн мэдүүлэгт үнэн зөв мэдүүлнэ².

4.Зорчигчийн хувийн хэрэглээний эмийг улсын хилээр нэвтрүүлэх:

Улс хоорондын үйлчилгээний төмөр зам, автобус, хөлөг онгоц, нисэх онгоц болон хувийн тээврийн хэрэгслээр зорчигч нь өөрийн хэрэгцээнд зориулан авч яваа эмийг “Зорчигчийн хувийн хэрэглээний эм” гэнэ.

-Зорчигчийн хувийн хэрэглээний эмийг импортын бараа гэж үзэхгүй ба импортын зөвшөөрөл шаардахгүй.

-Зорчигчийн хувийн хэрэглээний эмэнд яаралтай тусламж (7 хүртэл хоног)-ийн эм болон удаан хугацаанд нөхөх эмчилгээ шаардах (чихрийн шижин, хорт хавдар, сэтгэцийн эмгэг, дархлалын олдмол хомсдол зэрэг) өвчтэй хүмүүсийн хэрэглэдэг эм багтана.

-Дараах төрлийн эмийг хувийн хэрэглээний зориулалтаар улсын хилээр нэвтрүүлэхийг ХОРИГЛОНО:

- судсаар сэлбэх шингэн;
- антибиотик тариа;
- мансууруулах, сэтгэцэд нөлөөт эм;
- цусны бэлдмэл сийвэн орлох эм;
- нийтлэг дархлаажуулалтад хэрэглэх эм, бэлдмэл.

5. Гаалийн бүрдүүлэлт

-Тусгай журам тогтоогоогүй бол зорчигчийн биедээ авч яваа хувийн хэрэглээний эд зүйл болон биеэс тусдаа ачаа тээш, чингэлгээр явуулсан бараанд гаалийн бүрдүүлэлт хийх үндэслэл нь зорчигчийн гаалийн мэдүүлэг болно;

-Зорчигч гаалийн мэдүүлгийг нөхөн бичиж гарын үсэг зурж гаалийн улсын байцаагчид өгнө. Зорчигч биеэс тусдаа явуулсан ачаанд гаалийн мэдүүлгийг 2 хувь бичих ба нэгдүгээр хувийг хилийн гаалийн байгууллага авч, хоёрдугаар хувийг биеэс тусдаа илгээсэн бараанд гаалийн эцсийн бүрдүүлэлт хийх гаалийн байгууллагад хүргүүлэхээр эзэнд нь өгнө;

Тайлбар:

² - Эх сурвалж:

Монгол Улсын "Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй гэмцэх тухай хууль (шинэчилсэн найруулга)"-ийн "15 дугаар зүйл.Монгол Улсын хилээр бэлэн мөнгө оруулах, гаргах":

15.1.Зорчигч 15 саяас дээш төгрөг, эсхүл түүнтэй тэнцэх хэмжээний гадаад валют, санхүүгийн хэрэгсэл, цахим мөнгийг Монгол Улсын хилээр бэлнээр нэвтрүүлэх бол энэ тухай гаалийн мэдүүлэгт үнэн зөв мэдүүлнэ.

-16 насанд хүрээгүй зорчигчийн барааг эцэг, эхийн эсхүл асран хамгаалагчийн гаалийн мэдүүлэгт бичнэ;

-Зорчигчийн бусдад дамжуулах барааг тухайн зорчигчийн бараа, эд зүйлд тооцох бөгөөд зорчигч гаалийн мэдүүлэгт бичиж мэдүүлсэн байна;

- Гаалийн улсын байцаагч зорчигчийн гаалийн мэдүүлгийг хүлээн авсан үеэс зорчигч гаалийн байгууллагад мэдүүлсэн гэж үзнэ;

- Дамжин өнгөрөх зорчигчийн гаалийн мэдүүлэгт тэмдэглэсэн бараа нь Монгол Улсад орсон үеэс гарах хүртэлх хугацаанд гаалийн хяналтанд байна;

- Зорчигчийн гар тээш болон аялж буй тухайн тээврийн хэрэгслийн ачаа тээшин дэх барааг дагалдах ачаанд, зорчигчоос өөр тээврийн хэрэгсэл болон чингэлгээр ирүүлсэн /явуулсан/ барааг биеэс тусдаа ачаанд хамааруулна.

Танд лавлах зүйл байна уу!



1800-1281

Гааль сонсож байна



Талархал



Гомдол



Асуулт



Санал

ГААЛИЙН ЛАВЛАХ УТАС

Гаалийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой асуудлаар үйлчлүүлэгч иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын санал, хүсэлт, гомдол, мэдээллийг хүлээн авах, гаалийн хууль тогтоомж, заавар, журам, гаалийн үйлчилгээний талаар мэдээ, мэдээллээр хангах, сан бүрдүүлэх зорилгоор “Гаалийн лавлах-1281” нээлттэй утас ажиллуулж байна.

Гаалийн байгууллагын үйл ажиллагааны талаархи иргэд, байгууллагын асуултуудыг нэгтгэн, дүн шинжилгээ хийж, дүгнэлт гарган мэдээлэл, гомдол саналын мөрөөр шаардлагатай арга хэмжээ авах, хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран ажиллаж, мэдээлэл, зөвлөлгөө өгөх, сурталчилгаа хийх болон гаалийн зөрчлөө урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлж байна.



Хаяг:

Сүхбаатар дүүрэг, "Их тойруу-81/1",

Улаанбаатар-14193, Монгол Улс

Утас: (976-11) - 351986; 70130070

Факс: (976-11) - 350048

E-mail: info@customs.mn

Интернет: <http://www.customs.gov.mn>



МОНГОЛ УЛСЫН
ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР

ГААЛИЙН ХЯНАЛТЫН ХОС ГАРЦЫН СИСТЕМ



УЛААНБААТАР ХОТ
2019 ОН

1. Гаалийн хяналтын хос гарцын систем¹

“Хос гарцын систем” гэж ирж буй зорчигчдод хоёр төрлийн гарцын аль нэгийг сонгох замаар гаалийн байгууллагад мэдүүлэх гаалийн хяналтын хялбарчилсан системийг хэлнэ.

“Ногоон” өнгөөр ялгасан нэг гарц нь гаалийн татваргүй нэвтрүүлэх тоо хэмжээ, үнийн дүнгээс хэтрээгүй, мөн импортын хориг, хязгаарлалтад хамрагдаагүй бараа авч яваа зорчигчид ашиглах зориулалттай байна.

ГААЛИЙН ХЯНАЛТЫН ХОС ГАРЦЫН СИСТЕМ



“Улаан” өнгөөр ялгасан нөгөө гарц нь бусад зорчигчид ашиглах зориулалттай байна.

1.1. “Ногоон гарц”-аар нэвтэрч буй зорчигч энэхүү журам болон гаалийн хяналтаар илэрсэн, эсхүл гаалийн байгууллага энэ талаар мэдээлэл авсан бол гаалийн шалгалт хийнэ. Гаалийн шалгалтаар зорчигч хууль, тогтоомж зөрчсөн нь тогтоогдвол холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээнэ.

1.2. “Улаан гарц”-аар дараах тохиолдолд нэвтэрнэ:

- Гаалийн болон бусад татвар төлөх бараатай;
- Биеэс тусдаа явуулсан ачаатай;
- Гуравдагч этгээдэд дамжуулах бараатай;

Тайлбар:

¹ - Хос гарцын систем (хоёр гарцын тогтолцоо, the dual-channel system, двухканальная система) нь гаалийн байгууллага улсын хилээр орж ирж буй зорчигчийн урсгалыг боловсронгуй болгох, мөн зорчигчдын өсөн нэмэгдэж буй тоонд тохируулан гаалийн байгууллагын боловсон хүчнийг нэмэлгүйгээр гаалийн хяналтыг үр дүнтэй явуулах боломжийг бүрдүүлсэн хялбарчилсан систем юм. Хос гарцын системийг бусад хяналт, тухайлбал, валютын хяналт болон авто тээврийн хэрэгслийн даатгалын гэрчилгээний хяналттай хамтатган ашиглаж болно. Гэвч бүх зорчигч, тэдний бүх ачаа тээш, мөн хэрэв байгаа бол, бүх тээврийн хэрэгслийг хянаж шалгавал хос гарцын системийн ашиг тус гэж байхгүй болно.



- 5 саяас дээш төгрөг, эсхүл түүнтэй тэнцэх хэмжээний гадаад валют, санхүүгийн хэрэгсэл, цахим мөнгө (ГЕГ-ын даргын 2008 оны 468 дугаар тушаалын Нэгдүгээр хавсралтаар батлагдсан "Зорчигчийн хувийн хэрэглээний эд зүйлийг гаалийн хилээр нэвтрүүлэх журам").

2.Зорчигчийн хувийн хэрэглээний эд зүйл:

Аяллын үеэр зорчигчийн хувийн хэрэглээнд шаардагдах эд зүйл (шинэ болон хуучин), очих газар хүртэл хэрэглэхэд хүрэлцэх дахин боловсруулалт шаардагдахгүй хүнсний бараа болон тухайн зорчигчийн аяллын зорилго, хугацааг харгалзан дараах барааг хамааруулна. Үүнд:



3.Зорчигчийн биедээ авч яваа валютыг гаалийн хилээр нэвтрүүлэх талаар:

-Монгол Улсын болон гадаадын иргэн, харьяалалгүй хүн биедээ авч яваа валютыг гаалийн байгууллагад мэдүүлсэн тоо хэмжээгээр улсын хилээр оруулж болно. Монгол Улсын иргэн чөлөөтэй хөрвөдөг гадаад валютыг гаальд мэдүүлсэн тоо хэмжээгээр, гадаадын иргэд, харьяалалгүй хүний валютыг гадааас оруулсан гаалийн мэдүүлэг, банкнаас худалдан авсан баримтыг үндэслэн улсын хилээр гаргана;

-Гүйлгээнээс хасагдсан мөнгөн тэмдэгтийг цуглуулгын журмаар тус бүрээс зохих нэгжээр нэг ширхэгийг улсын хилээр нэвтрүүлэхийг зөвшөөрнө.